



# ХӨВСГӨЛ УСАН ЗАМ ХК

Энх тайвны өргөн чөлөө 44, Улсын Их Дэлгүүр, 5 давхар,  
Ш/Х-688, Улаанбаатар 210644, Монгол улс  
Утас: (976-11)-313232, Факс: (976-11)-314242  
E-mail: nomin.net

2021 оны 04 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар: 01

Улаанбаатар  
хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.16 дахь хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2021 оны 04-р сарын 27-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг Хавсралт №1-ээр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



С.САЙНБАТ

“Хөвсгөл усан зам” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны  
04-р сарын 27-ны өдрийн ээлжит хурлын 01 тоот тогтоолын Хавсралт №1



**Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2021 оны зардлын төсөв**

(мянган төгрөгөөр)

1. Бүх гишүүдийн хурлын заал, бичиг хэрэг, нотариат	245.0
2. Хурлын зар өгөх, тархалтын судалгааны зардал	236.0
3. Хараат бус гишүүдийн цалин, НДШ	1362.0
4. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга цалин, НДШ	1021.5
<b>Нийт зардал</b>	<b>2864.5</b>



# ХӨВСГӨЛ УСАН ЗАМ ХК

Энх тайвны өргөн чөлөө 44, Улсын Их Дэлгүүр, 5 давхар,  
Ш/Х-688, Улаанбаатар 210644, Монгол улс  
Утас: (976-11)-313232, Факс: (976-11)-314242  
E-mail: nomin.net

2021 оны 04 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар: 02

Улаанбаатар  
хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, компанийн дүрмийн 7.3.4 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04-р сарын 27-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг сонгосугай. Үүнд:
  - 1.1. Шагдарсүрэнгийн Баярсайхан
  - 1.2. Амарбаярын Шагдарсүрэн
  - 1.3. Санжаагийн Сайнбат
  - 1.4. Алтангэрэлийн Норсмаа
  - 1.5. Жагваралын Мөнхбаатар
  - 1.6. Доржпаламын Оюунцэцэг
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг сонгосугай. Үүнд:
  - 2.1. Дашдондогийн Дашцэдэн
  - 2.2. Нанзадын Отгонбаатар
  - 2.3. Пүрэвийн Эрдэнэболд
3. Холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм, дотоод үйл ажиллагааны дүрэм, журам зэрэг компанийн засаглалын тогтолцооны эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллахыг шинээр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.
4. Шинээр томилогдсон ердийн болон хараат бус гишүүдийн талаарх мэдээллийг холбогдох эрх зүйн актад тусгасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржид тус тус мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Өлзийбат/- д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С.САЙНБАТ



# ХӨВСГӨЛ УСАН ЗАМ ХК

Энх тайвны өргөн чөлөө 44, Улсын Их Дэлгүүр, 5 давхар,  
Ш/Х-688, Улаанбаатар 210644, Монгол улс  
Утас: (976-11)-313232, Факс: (976-11)-314242  
E-mail: nomin.net

2021 оны 04 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар: 03

Улаанбаатар  
хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийг татан буулгахаас татгалзах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.5 дахь хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04-р сарын 27-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөвсгөл усан зам” ХК-ийг татан буулгахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. “Хөвсгөл усан зам” ХК-ийг татан буулгах эсэх асуудлыг компанийн үйл ажиллагаа, бизнес төлөвлөгөөтэй уялдуулан холбогдох судалгаа, харьцуулалт хийсний үндсэн дээр Хувьцаа эзэмшигчдийн хуралд дахин танилцуулж, шийдвэрлүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



С.САЙНБАТ